



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 4/624

Булган сум

Г Булган аймгийн төв суурин газрын
2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын
нэгдсэн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төв суурин газрын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын нэгдсэн төлөвлөгөөг 1 дүгээр, аймгийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг ажлын хэсгийн гишүүд, сумдын Засаг дарга нар, байгууллагын дарга, эрхлэгч наарт даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Аймгийн Засаг даргын орлогч дарга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг Дарын 20... оны
дүгээр сарын 15.-ны/ний өдрийн 1 дугаар
захирамжийн 1 дугээр хавсралт

Булган аймгийн төв суурин газрын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангулах нэгдсэн төвлөгөө

| Д/Д | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах байгууллага | Хянгаалт тавих байгууллага |
|-----|---|----------------------------|------------------------------------|---|-----------------------------------|
| | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын нэгдсэн төвлөө боловсруулж батлуулах | 9 дүгээр сарын 15-ны дотор | АЗДТГ ХБТХОХ | Тусгай зөвшөөрөл эзэмшигч, сумдын Засаг дарга | Аймгийн Засаг даргын орлогч дарга |
| 2 | Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах батлагдсан аймгийн нэгдсэн төвлөвлөгөөг сумдууд болон холбондоо байгуулагуудад хүргүүлэх | 9 дүгээр сарын 15-ны дотор | АЗДТГ ХБТХОХ | Сумдын Засаг дарга | Аймгийн Засаг даргын орлогч дарга |
| 3 | Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах сумын нэгдсэн төвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Сумын Засаг дарга | АЗДТГ ХБТХОХ | Сумын Засаг дарга |
| 4 | Төвлөрсөн халаалтын системд холбогдоогүй, тусдаа бие даасан объектын халаалтын зуух болон цахилгаанаар халаадаг байгууллага, аж ахуйн нэгжүүд тулш, нүүрсийг 30 хоногийн нөөцтэйгөөр татан авч, галлагааг мэрэжлийн ажилтнаар гүйцэтгүүлэх. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Байгууллага, аж ахуй нэгж | АЗДТГ ХБТХОХ | Сумын Засаг дарга |
| 5 | Төвлөрсөн халаалтын шугам сүлжээнд холбогдсон эзэмшилийн гадна шугам сүлжээ, худаг, барилгын дотор шугам хоолойн халаалт дулаан авах бэлэн байдалд Узлэг шалгалт хийж, мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээг түйцэтгүүлж дуусгах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Сумын халаалтын зуухны газар | Байгууллага, аж ахуй нэгж | Сумын Засаг дарга |
| 6 | Насжилт өндөр, дулааны алдагдал ихтэй барилгын дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Байгууллага, аж ахуй нэгжийн дарга | АЗДТГ ХБТХОХ, ГХБХБГ | Сумын Засаг дарга |
| 7 | Сумдад барилга, байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр зөвлөмж гаргаж хүргүүлэх | 9 дүгээр сарын 20-ны дотор | ГХБХБГ | АЗДТГ ХБТХОХ | Сумын Засаг дарга |

| | | | | | |
|----|---|-----------------------------|---|--------------------------------------|---|
| 8 | Цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх дамжуулах, түгээх компаниудын 2024-2025 оны засварын төлөвлөгөөний эхийтэл ажлын их болон ургсал хяналт тавьж, аюулгүйн сэлбэг, материалын нөөцийг жагсалаалтын дагуу бурдудлах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Тусгай зөвшөөрөл эзэмшигч /Сумын халаалтын зуухны газар/ | Эрчим хүчиний зохицуулах зөвлөл | Сумын Засаг дарга, АЗДТГ ХБТХОХ |
| 9 | Эрчим хүчиний найдваржилтийн 1, 2-р зэрэглэлд хамаарах байгууллагууд, болзошгүй аваар, саатлын үед нөөц цахилгааны эх үүсгэврийн бэлэн байдлыг хангуулах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Тусгай зөвшөөрөл эзэмшигч, байгууллага, аж ахуй нэгжийн дарга | Эрчим хүчиний зохицуулах зөвлөл | Сумын Засаг дарга "ЭБЦС" ТӨХК-ийн Булган салбар |
| 10 | Эрчим хүчиний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд "Гамшигаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө"-г батлуулсан байх. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар | Онцгой байдлын газар | Сумын Засаг дарга |
| 11 | Эрчим хүчиний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд зуух, тоноглол, шугам сүлжээний техникийн агуулгүй байдал, технологийн хэвийн үйл ажиллагааг хангуулах талаар зөвлөмж хургуулэх. | 9 дүгээр сарын 15-ны дотор | АЗДТГ ХБТХОХ | Сумдын халаалтын зуухны газрууд | АЗДТГ ХБТХОХ, Сумын Засаг дарга |
| 12 | Авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах талаар зөвлөмж хургуулэх | 9 дүгээр сарын 20-ны дотор | АЗДТГ ХБТХОХ | "Булган Азза" ТӨХК Сумын Засаг дарга | АЗДТГ ХБТХОХ Сумын Засаг дарга |
| 13 | Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, аж ахуйн нэгжид хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулах талаар зөвлөмж хургуулэх | 9 дүгээр сарын 20-ны дотор | Стандарт хэмжилзүйн хэлтэс | Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар | АЗДТГ ХБТХОХ Сумын Засаг дарга |
| 14 | Цахилгаан, дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх компаниудын хэмжих хэрэгслийн эзлжит баталгаажуулалтын ажлыг батлагдсан графикийн дагуу хийж дуусгах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Стандарт хэмжилзүйн хэлтэс | Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар | АЗДТГ ХБТХОХ Сумын Засаг дарга |
| 15 | Төв хангуулсан байдлыг шалгаж, үнэлгээ өгөх хуудас боловсруулж сумдад хургуулэх. | 09 дүгээр сарын 20-ны дотор | АЗДТГ ХБТХОХ | | Сумын Засаг дарга |
| 16 | Эрчим хүчиний шугам сүлжээний хамгаалалтын зурваст орсон хэрэглэгч нарт болзошгүй эрдээлээс урьдчилан сэргийлж мэдэгдэл хургуулэх ажлыг зохион байгуулах. | 9 дүгээр сарын 30-ны дотор | Сумын Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар | | АЗДТГ ХБТХОХ |

| | | | | | | |
|----|---|------------------------------|---|-------------------|-------|--------------|
| 17 | Улсын болон орон нутгийн чанартай авто зам, гүүр, хоолойн ургсал засвар, давааны замыг батлагдсан график төлөвлөгөөний дагуу чанартай хийж дуусгах. | 10 дугаар сарын 01-ний дотор | “Булган АЗЗА” ТӨХК | Сумын дарга | Засаг | АзДТГ ХБТХОХ |
| 18 | Өвлийн улиралд авто замын арчилгаанд зориулан давс, элс, хайрга, бодис бэлтгэж нөөцлөх. | 10 дугаар сарын 01-ний дотор | “Булган АЗЗА” ТӨХК, Булган сумын тохижилт үйлчилгээний анги | Сумын Засаг дарга | Засаг | АзДТГ ХБТХОХ |

Аймгийн Засаг даргын 20^ж оны
09 дүгээр сарын 13.-ны/ний өдрийн 11/6/24 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч дарга
Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Сумдын Засаг дарга нар
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын дарга
“ЭБЦТС” ТӨХК-ийн Булган салбарын дарга
“ЦДУС” ТӨХК-ийн Хангай бусийн салбарын Булган
хэсгийн Ашиглалт, шуурхай үйлчилгээний инженер
“Энержи плас” ХХК-ийн Гүйцэтгэх захирал
“Булган Мээж” ХХК-ийн Захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгч
“Булган АЗЗА” ТӨХК-ийн Ерөнхий инженер
Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Автозамын
хяналтын улсын байцаагч